

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС:

Умард гүвээт халхын дундад сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хамтран 2023 оны 07 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Сүмбэр сумын хэмжээнд 24 булаг, гол, нуурын тооллогын ажлаар газар дээр очиж солбицолжуулах, зурагжуулах хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/191 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг сүмбэр сумын 2 дугаар багт, аймгийн холбооны газрын баруун талд 0.0906 га /906м²/ газрыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар 2022 оны 07 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажлаад байна.




Хот тосгон, бусад суурин газрын мониторингийн цэгт хөрсний бохирдлын судалгааны ажлын хүрээнд аймгийн төвийн суманд 10 цэгт хөрсний дээж авахаар ажилллаж байна.



Барилга, хот байгуулалтын хэлтэс:


1. 2023.06.30-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв хамтран зохион байгуулсан Барилга угсралтын ажлын чанар улсын форумд байгууллагын 2 албан хаагч оролцлоо.



2. Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн Л.Элбэгийн 2 давхар худалдаа үйлчилгээний зориулалттай барилгад 2023.07.05-ны өдөр улсын комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэлээ.



3. Аймгийн төвийн 2.8 км автозамын ажилтай захиалагч, гүйцэтгэгч, зохиогч байгууллагын төлөөллүүд 2023.07.20-ний өдөр газар дээр нь үзлэг шалгалт



хийж ажиллалаа. Ажлын гүйцэтгэл 75 хувьтай явагдаж байна.

4. Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа Боржигон чуулгын барилгын гадна дотно ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Ажлын явц: 93%-тай

